

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2022.12.01

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ТАТВАР ТӨЛӨГЧ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ТАТВАР ТӨЛӨХ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ, ЭРХЭЭ ЭДЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЖ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ							
НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Татвар төлөгчийн төрлийн тоог нэмэгдүүлэх ажлын зохион байгуулах		Татвар төлөгчийн тоо	43505	45245	Татвар төлөгчийн баазыг 2934 татвар төлөгчөөр бүртгэж 5.6 хувиар нэмэгдүүлж 46439 татвар төлөгчийг 100 хувь бүртгэсэн.	100
1.1	УБЕГ-т бүртгэлтэй боловч Татварын албанд бүртгэгдээгүй хуулийн этгээдийг эрэн сурвалжилж, бүртгэх		Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдийг бүрэн бүртгэсэн хувь	100	100	2022 онд УБЕГ-т бүртгэгдсэн 93 хуулийн этгээдийг мэдээллийн дагуу холбогдон "Татвар төлөгчийн бүртгэлийн" журмын дагуу 100 хувь ТУНС-д бүртгэж, хувийн хэрэг нээлээ.	100
1.2	Борлуулалтын орлого нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх хэмжээнд хүрсэн татвар төлөгчийг бүрэн бүртгэх		Бүртгэгдсэн тоо	27	35	Борлуулалтын орлого НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх хэмжээнд хүрсэн 36 татвар төлөгчийн НӨАТ суутган төлөгчөөр бүртгэж гэрчилгээг цахимаар хүргүүллээ.	100
1.3	Үйл ажиллагааны орлого бүхий хувь хүнийг татвар төлөгчийн бүртгэлд бүрэн хамруулах		Бүртгэгдсэн тоо	31938	34147	ХХОАТ-ийн төрлөөр 2022 оны эхэнд 31938 татвар төлөгч бүртгэлтэй байгаа бөгөөд тайлант хугацаанд 2214 татвар төлөгч шинээр бүртгэгдэж нийт 34152 татвар төлөгч бүртгэлтэй байна.	100
1.4	Хөрөнгийн татвар төлөгчийг нэмэгдүүлсэн байх.		Бүртгэгдсэн тоо	11500	11810	2022 оны 11500 татвар төлөгч бүртгэлтэй бөгөөд тайлант онд 591 татвар төлөгч нэмэгдэж нийт 12091 татвар төлөгч бүртгэлтэй байна.	100
2	Татварын тайлагналыг ирцийн хувийг нэмэгдүүлэх		Цахимаар ирүүлсэн тайлангийн хувь	81	95	Татвар төлөгчөөс татварын 4302 тайлан хүлээн авахаас 4139 тайлан хүлээн авч 96 хувийн гүйцэтгэлтэй байна.	100

1	2	3	4	5	6	7	8
2.1	Татварын тайлан ирүүлбэл зохих татвар төлөгчийн сар, улирал, жилийн тайлангуудыг хуулийн хугацаандаа хүлээн авах.		Цахимаар ирүүлсэн тайлангийн хувь	81	85	Татвар төлөгчийн татварын тайланг 100 хувь цахимаар хүлээн авч байна. Үүнээс: 1.Аж ахуй нэгжийн орлогын албан татварын 516 тайлан хүлээн авахаас 443 тайлан хүлээн авч 86 хувь, 2.Суутган-1 татварын тайлан 1039 татвар төлөгч ирүүлэхээс 971 нь буюу 93 хувь, 3. Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн 2640 тайлан хүлээн авахаас 2620 тайлан хүлээн авч 99 хувь, 4.Дотоодын архины онцгой албан татварын 11 тайлан хүлээн авахаас 11 тайлан хүлээн авч 100 хувь 5. Ашигт малтмал нөөц ашигласны төлбөрийн тайлан 53 тайлан хүлээн авахаас 51 тайлан хүлээн авч 98 хувь, 6. Улсын тэмдэгтийн хураамж 43 тайлан хүлээн авахаас 43 тайлан хүлээн авч 100 хувь хүлээн авсан байна. Тайлант жилд нийт 4302 тайлан хүлээн авахаас 4139 тайлан хүлээн авч 96 хувийн гүйцэтгэлтэй байна	100
2.2	Татварын тайлан боловсруулалт, зөрчилтэй тайланг бүрэн засварлуулах.		Засварласан тайланг хүлээн авсан хувь	-	90	Татвар төлөгчдийн цахим татварын системд илгээсэн тайлангаас тайлан боловсруулалтын шалгуур үзүүлэлт хангаагүй 387 тайлан хуваарилагдан ирсэнийг татвар төлөгчид буцаан 353 тайлан буюу 91 хувийг залруулан хүлээн авсан байна.	100
2.3	Татвар төлөгчийн цахимаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх.		Хугацаанд нь шийдвэрлэсэн хувь	-	90	Цахим татварын системд татвар төлөгчийн тайлан залруулах, хуулийн хугацаа сунгуулах, татварын тоон гарын үсэг авах, татвар төлөгчийн төрлийн бүртгэл нэмэх, хасах зэрэг нийт 3287 хүсэлт ирүүлсэнээс 3152 хүсэлтийг 96 хувьтай шийдвэрлэн ажилласан байна.	100
3	Төсвийн орлогыг бүрдүүлэх		Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	86.1	100	Орлогын 9595651,4 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 10386165,6 мянган төгрөг төвлөрүүлж 108 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.	100
3.1	Татварын орлогын хэмжээг 2020 онд 7697110.4 мянган төгрөг байсныг жил бүр 2 хувиар нэмэгдүүлнэ.		Татварын орлогын баазыг нэмэгдүүлсэн дүн	7,697,110.40	8,008,073.60	Татварын орлогын хэмжээг 2020 онд 7697110.4 мянган төгрөг байсныг жил бүр 2 хувиар нэмэгдүүлж 10095074.0 мянган төгрөгийн бүрдүүлж 100 хувь ханган биелүүлсэн байна.	100
3.2	Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт		Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	86.1	100	Улсын төвлөрсөн төсөвт 1606826.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 1863204.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 116 хувийн гүйцэтгэлтэй байна.	100

Commented [OE1]: Татварын орлогын бааз гэдгийг би юү гэж ойлгох үү

1	2	3	4	5	6	7	8
3.3	Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт		Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Аймгийн төвлөрсөн төсөвт 565782.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 977581.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 173 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
3.4	Сумын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт		Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Сумын төвлөрсөн төсөвт 6793858.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 7238814.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 107 хувийн гүйцэтгэлтэй байна	100
3.5	Цалингийн орлогын төлөвлөгөөний биелэлт		Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Цалингийн орлогын төлөвлөгөө 3943100.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 4174585.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 106 хувийн гүйцэтгэлтэй байна	100
4	Татварын өрийн барагдуулалтыг 80 хувьд хүргэнэ		Татварын өрийг барагдуулалтын хувь	32	80	Татварын өрийн барагдуулалтыг стандарт түвшинд хүргэж 87 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байгаа нь хүрэх түвшинг бүрэн хангаж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.	100
4.1	Татварын тайлангаар ногдуулсан татварын өрийг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх		Урд оны татварын өрийг барагдуулалтын хувь	42	75	Эхний 11 сарын байдлаар татварын тайлангаар ногдуулсан урьд оны өр 3900398.9 мянган төгрөгөөс 2379243,3 мянган төгрөгийн өрийг барагдуулж өрийн барагдуулалт 61 хувь байна. 2022 оны 12 сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр 600000,0 мянган төгрөгийн өрийг барагдуулахаар хүлээгдэж байна. Нийт тайлант онд 76 хувийн өр барагдуулна.	100
			Тайлант оны татварын өрийг барагдуулалтын хувь	74	90	Эхний 11 сарын байдлаар татварын тайлангаар ногдуулсан тайлант оны 9605920.6 мянган төгрөгөөс 7780795.69 мянган төгрөгийн өрийг барагдуулж өрийн барагдуулалт 81 хувь байна. 2022 оны 12 сард 1000000,0 мянган төгрөгийн өрийг барагдуулж хүлээгдэж буй гүйцэтгэлээр 91 хувьд хүрнэ.	100
4.2	Хяналт шалгалтаар ногдуулсан татварын өрийг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх		Урд оны татварын өрийг барагдуулалтын хувь	1	75	Эхний 11 сарын байдлаар хяналт шалгалтын урьд оны өр 3132168.5 мянган төгрөгөөс 2035909.5 мянган төгрөгийн өрийг барагдуулж өрийн барагдуулалт 65 хувь байна. 2022 оны 12 сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр 350000.0 мянган төгрөгийн өрийг барагдуулахаар хүлээгдэж байна. Нийт тайлант онд 76 хувийн өрийг барагдуулахаар хүлээгдэж байна.	100

			Тайлант оны татварын өрийг барагдуулалтын хувь	10	80	Эхний 11 сарын байдлаар хяналт шалгалтын актаар ногдуулсан 1036408.8 мянган төгрөгөөс 780388.9 мянган төгрөгийн өрийг барагдуулж өрийн барагдуулалт 75 хувь байна. 2022 оны 12 сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр 60000.0 мянган төгрөгийн өрийг барагдуулахаар хүлээгдэж байна. Нийт тайлант онд 81 хувийн өрийг барагдуулахаар хүлээгдэж байна.	100
4.3	Хугацаандаа төлөгдөөгүй татварын өрийг хураан барагдуулах зорилгоор зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй хамтран ажиллах		Татварын өрийг шат дараалсан арга хэмжээний дагуу хамтран ажилласан тоо		20	Татварын өрийг төлөөгүй 23 татвар төлөгчийн 958795.0 мянган төгрөгийн өрийг барагдуулахаар банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг битүүмжилсэн. Мөн 2 татвар төлөгчийн 54524.0 төгрөгийн өрийг барагдуулахаар эд хөрөнгийг битүүмжилсэн	100
5	Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг 76 хувьд хүргэн ажиллах		Хуулийн хэрэгжилтийн хувь	56	90	Хуулийн хэрэгжилтийг 94 хувьд хүргэн ажиллалаа.	100
5.1	Холбогдвол зохих татвар төлөгчийн 95 хувийг холбосон байна.		Холбогдвол зохих татвар төлөгчийг 95 хувийг холбосон байна.	91	95	Бүртгэгдвэл зохих 3133 татвар төлөгчийг шинээр бүртгэлжүүлж 100 хувь холбосон байна.	100
5.2	Нэгдсэн системд холбогдсон татвар төлөгчийн төлбөрийн баримт илгээж буй байдалд хяналт тавих		Нэгдсэн системд холбогдсон татвар төлөгчийн төлбөрийн баримт илгээлт суурь түвшингээс 10 хувиар нэмэгдсэн байх	6	75	Хэлтсийн даргын баталсан ажил сайжруулах удирдамж, төлөвлөгөөг ажлын 4 хэсэгт гарган нэгдсэн арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна. 1. Зах худалдааны төвд үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн суурь түвшин 3 сарын 1-ны байдлаар 499 төлбөрийн баримт олгож байсан бол 11 сарын 30-ны байдлаар 4163 төлбөрийн баримт олгогдож зорилтот түвшингээс 20 хувиар нэмэгдсэн байна. 2.Байгууллагаас 711 хуулийн этгээдийн төлбөрийн баримт олгохоос 369 татвар төлөгч төлбөрийн баримт олгож 51 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт 76 хувийн гүйцэтгэлтэй байна	100
5.3	Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийг хэрэгжүүлээгүй татвар төлөгчид хариуцлага тооцох		Хуулийг хэрэгжүүлээгүй татвар төлөгчид хариуцлага тооцох тоо	8	30	Хууль хэрэгжүүлээгүй төлбөрийн баримт олгоогүй 65 татвар төлөгчид 32,8 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.	100
5.4	Нэгдсэн системээс төлбөрийн баримт хэвлэж олгоогүй гомдол шийдвэрлэлтийн байдал		Гомдол шийдвэрлэлтийн хувь	68	95	Тайлант хугацаанд нийт 255 гомдол хуваарилагдсан бөгөөд 245 гомдлыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж 96 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.	100
6	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус татвар төлөгчийг 100 хувь татварын хяналт шалгалтад хамруулах		Хэрэгжилтийн хувь	100	100	Татварын хяналт шалгалтыг 100 хувь хийж гүйцэтгэсэн.	100

Commented [OE2]: Энэ арга хэмжээний шалгуур нь арай өөрөөр томъёолж болох уу. Жнь дансыг битүүмжилснээр барагдуулсан өрийн шийдвэрлэлтийн хувь ч гэх юмүү

Commented [OE3]: Мөн адил

Commented [OE4]: Шаргуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлох

Commented [OE5]: Иргэдээс ирсэн ӨГ-ын бууралт ч гэх юм уу мөн хяналт шалгалт хийсэн тоо гэ мэтээр

Commented [OE6]: Энэ арга хэмжээ мөн үү

1	2	3	4	5	6	7	8
6.1	Эрсдэлд суурилсан татварын төлөвлөгөөт хяналт шалгалт хийх.		Татварын хяналт шалгалт хийсэн хувь.	100	100	Эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх зорилгоор төрөөс барьж буй бодлогын хүрээнд татварын төлөвлөгөөт хяналт шалгалтын үйл ажиллагаа хийгдээгүй болно.	-
6.2	Эрсдэлд суурилсан татварын төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх		Татварын хяналт шалгалт хийсэн хувь.	100	100	2022 онд эрсдэлд суурилсан төлөвлөгөөт бус татварын хяналт шалгалтад 14 татвар төлөгчийг хамруулахаас 14 татвартөлөгчийг шалгаж гүйцэтгэл 100 байна.	100
6.3	Татвар төлөгчөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу татварын маргааныг маргаан таслах зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлэх		“Татварын маргаан таслах журам”-ын дагуу хугацаандаа шийдвэрлэгдсэн гомдол, маргааны эзлэх хувь	-	100	Татварын маргаан таслах зөвлөлд гомдол ирээгүй учир шийдвэрлэлт явагдаагүй болно.	-
6.4	Иргэний, захиргааны хэргийн шүүхэд татварын албыг төлөөлж ажилласан байх		Хэрэг, маргаан татварын албаны талд шийдвэрлэгдсэн тоо		100	Дундговь аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхэд Хөрх булаг ХХК-ний нэхэмжлэлтэй Бөхт ХХК-д холбогдох гомдол хэлэлцэх тухай шүүх хуралд 1 удаа оролцож өөрийн талд 100 хувь шийдвэрлүүлсэн.	100
6.5	Зөрчлийн тухай хуулийн 11.19 дэхь заалтын хэрэгжилтийг хангах		Шийтгэлийн хуудасны хүчин төгөлдөр байдлын хувь	100	100	Тайлант хугацаанд 65 татвар төлөгчид хариуцлага тооцон тухай бүрт нь Прокурорын байгууллагад хянуулан бүгд хүчин төгөлдөр болж баталгаажсан.	100
ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ							
1	Зорилт 1. Татвар төлөгчид Татварын боловсролын жилийн хүрээнд мэдээ, мэдээлэл түгээн ажиллах, иргэдийн санал гомдлыг шийдвэрлэх		Мэдээлэл түгээсэн тоо	9105	9800	Мэдээ 598, 147 мэдээлэл түгээн, 9235 татвар төлөгчид зөвлөгөө өгч, 31 удаагийн сургалт хийж, 561 иргэнийг хувь хүний орлогын албан татварын чөлөөлөт эдлүүлэн ажиллаж, 128 өргөдөл гомдол нийт 9980 мэдээлэл, зөвлөгөөг хуулийн хугацаанд 100 хувь бүрэн шийдвэрлэн ажилласан.	100
1.1	Татварын албаны цахим хуудсаар сурталчилгаа мэдээ, мэдээлэл байршуулах		Мэдээлэл байршуулсан тоо	90	120	Dundgovi.gov.mn-д Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын өөрчлөлтийн дагуу ил тод байдлыг хангах 23 шалгуур үзүүлэлтээр 3 бүлэг 23 үзүүлэлтэд хамаарах 23 үзүүлэлтэд 147 мэдээлэл байрлуулан ажилласан байна. Дундговь аймгийн Татварын хэлтэс page хуудсаар 2 видео, 598 мэдээ мэдээллийг түгээж, 23260 хэрэглэгч үзэж,11230 лайк, 1458 хэрэглэгч шейр хийж бусдад түгээсэн байна. Сургалтыг цахимаар болон танхимаар 3561 татвар төлөгчид 31 удаа зохион байгуулсан.	100

Commented [OE7]: Шалгуурыг оновчтой болгох хяналт шалгалт хийснээр ямар үр дүн хүлээж байгаагаа шалгуур үзүүлэлт болгох ер бүх арга хэмжээний шалгуурыг тэгж тодорхойлох

Commented [OE8]: Эрсдэлийн бүүралтын хувь гэж тодорхойлсон бол хийсэн ажлын чинь үр дүн илүү харагдах байсан байна гэж харж байна.

1	2	3	4	5	6	7	8
1.2	Татвар төлөгчийн татварын хууль, тогтоомжийн чиглэлээр гарын авлага, материалаар хангах		Бэлтгэсэн гарын авлага, материалын тоо	15	20	Татварын хуулиудаар 11 төрлийн брошур, 10 видео нийт 21 материал бэлтгэн 15483 татвар төлөгчид тараасан.	100
1.3	Татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийн талаар утсаар зөвлөгөө мэдээлэл, зааварчилгаа хүргэх		Мэдээлэл хүргэсэн тоо	9000	9100	Тайлант жилд 18001288 тусгай дугаарт дуудлага хүлээн авсан байцаагчийн хуваарь гаргаж 9235 санал хүсэлт, өргөдөл, гомдол ирсэнийг тухай бүр шийдвэрлэн ажилласан.	100
1.4	Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд удирдлага аргагүйгээр хангах тайланг хүлээн авах		Тухайн жилд хөнгөлөлт эдэлсэн иргэний тоо		560	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу нийт 561 иргэн хөнгөлөлтөд хамрагдаж, нийт 361436,6 мянган төгрөгийн буцаан олголтыг олголоо.	100
1.5	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн системээр бүртгэж, бүртгэл хяналтын карт хөтлөн ажиллах.		Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	100	100	1.Хуулийн этгээд, хувь хүнээс-96 албан хаагчдаас-32 нийт 128 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн байна. 2. Иргэний ибаримтын нууц үг сэргээх 1582 гомдол ирсэнийг тухай бүрт нь 100 хувь шийдвэрлэн ажилласан. 3.7059106 дугаарт ирсэн 1 гомдолыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. 4. Нийт 1711 гомдол ирсэн бөгөөд 1711 гомдлыг 100 хувь бүрэн барагдуулсан.	100
2	Зорилт 2. Татварын албаны хүний нөөцийг чадавхижуулах		Мэдээлэл түгээсэн тоо	17	85	Албан хаагчдыг чадваржуулах, төлөвлөгөөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу 100 хувь ажилласан.	100
2.1	Албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн сургалт зохион байгуулах		Сургалтад хамрагдсан тоо		34	Албан хаагч нэг бүртэй албан тушаалын тодорхойлолтод тулгуурлан гүйцэтгэлтийн төлөвлөгөө гарган, гүйцэтгэлийн тайлан гаргах талаар танхимын сургалтыг 34 албан хаагчид 2 удаа зохион байгуулсан.	100
2.2	Албан хаагчийн ажлын чиг үүрэг, хариуцсан ажлын хүрээнд зөвлөх, арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах		Сургалтад хамрагдсан тоо		34	Албан хаагчдын сургалт хөгжлийн хөтөлбөр батлан сургалтыг танхимаар 1 удаа, цахимаар 2 удаа нийт 34 албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан	100
2.3	2018 оны Ерөнхийлөгчийн 46 дугаар зарлигийн /Монгол бичгийн хэрэглээг эрчимжүүлэх тухай /дагуу албан хаагч бүр батламж авсан байх.		Батламж авсан албан хаагчийн тоо	17	17	Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахаар Ахмад багш Цэцэгмаатай хамтран ажиллаж 19 албан хаагч сургалтын дуусгаж сертификатыг гардан авсан.	100

1	2	3	4	5	6	7	8
2.4	Мэргэшүүлэх сургалтад хамруулах		1. Мэргэшүүлэх сургалтад хамрагдалтын хувь 2. Мэргэшүүлэх сургалтын дараах шалгалтын үнэлгээний хувь	-	80	Татварын хяналт шалгалтын тасаг 3 албан хаагч, Жижиг татвар төлөгчтэй харилцах тасаг 3 албан хаагч, Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн 14 албан хаагч 100 хувь хамрагдсан. Шалгалтын дундаж Татварын хяналт шалгалтын тасаг 75 хувь, Жижиг татвар төлөгчтэй харилцах тасаг 81 хувь, Бичил татвар төлөгчтэй харилцах тасаг 90 нийт 82 хувь гүйцэтгэв.	100
2.5	Төрийн албан хаагчийн ёс зүйн болон сэлгэх, шилжин ажиллах үеийн сургалт зохион байгуулах		1. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Шинээр 4 албан хаагч томилогдсон бөгөөд шилжин ажилласан 3 албан хаагчид тасгийн дарга Н.Мөнгөнтуяа, Ш.Мөнгөнцэцэг нар томилогдсон тухай бүрт нь сургалтыг 100 хувь гүйцэтгэж ажилласан.	90
2.6	Татварын албаны хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах		1. Сургалт хөгжлийн хөтөлбөрийн биелэлтийн хувь 2. Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн биелэлтийн хувь	97	98	Сургалт хөгжлийн хөтөлбөр гарган батлуулан хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж зорилтот түвшинг бүрэн хангасан байна. Нийгмийн баталгаа хангах хөтөлбөр гарган батлуулан хэрэгжилт 97 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж зорилтот түвшинг бүрэн хангасан байна.	100
2.7	Албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, дотоод болон гадаад сургалтад хамруулах		1. Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаанд албан хаагчдын хамрагдалтын хувь 2. Сургалтын төлөвлөгөө боловсруулсан хувь 3. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь		100	2022 онд 30 албан бүх албан хаагчдаас сургалтын хэрэгцээг тодорхойлох санал асуулгыг 100 хувь хамруулан авсан. 2 зорилт 29 арга хэмжээтэй сургалтын төлөвлөгөөг хэлтсийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн 100 хувиар баталсан Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.	100
3	Зорилт 3. Байгууллагын гаднах тохижилт хийх	5 сая төгрөг	Тохижилтийн хувь		100	Байгууллагын гаднах тохижилийг 90 хувь гүйцэтгэсэн байна.	90
3.1	Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн хүрээнд байгууллагад гэрэлтүүлэг хийх	0.5 сая төгрөг	Хийсэн гэрэлтүүлгийн тоо		7	Албан байгууллагын гадна тайлбайг засч 7 гэрэлтүүлэг суулгасан	100

Commented [OE9]: Сургалт хөгжлийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө 2 юугаараа ялгаатай бэ

1	2	3	4	5	6	7	8
3.2	Байгууллагын гадна тохижилт хийх		Ажил зохион байгуулсан хувь		100	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний 1 зам, 00-ын өрөөнд зориулалтыг 2 бариулыг шинээр тохижуулан хийв.	90
3.3	Татвар төлөгчийн хүлээлгийн сандал хийх	1 сая төгрөг	Байршуулах тоо		1	Татвар төлөгчид зориулан ногоон байгууламжийг ашиглан хүлээлгийн 2 сандал шинээр хийв.	100
3.4	Хог хаягдлыг ангилах зориулалтын савыг байршуулах	0.5 сая төгрөг	Байршуулсан савны тоо		3	Ангилан ялгах зориулалттай хог хаягдлын 1 сав шинээр хийж байршуулав.	33.3
3.5	Албанд ТЕГ-с баталсан зураг төсвийн дагуу шинэ байрны төсвийг 2023 онд төсөвт суулгах		2023 оны төсөвт суулгасан байх		100	Саналыг хүргүүлсэн боловч хэрэгжээгүй	0
3.6	Хуваарилагдсан газарт мод суулгаж арчлан ургуулах		Тарьсан модны тоо	108	120	Тайлант хугацаанд төв зам дагуу 32 мод нөхөн тарьж байгууллагын гадна талд 300 мод суулган хуваарь гарган услан арчилж байна.	100
3.7	Талбай хуваарилан авч зүлэгжүүлэх		Зүлэгжүүлсэн талбайн тоо		1	Генералуудын 1 талбайд 12 ширхэг мод суулгаж цагдаагийн газарт хүлээлгэн өгсөн. Мөн Сайнцагаан сумын ЗДТГ-ын урд садыг хуваарилан авч тохижилтыг хийж гүйцэтгэсэн.	0
3.8	Албаны гадна, дотор тайлбайг тохижуулан, цэцэрлэгжүүлэх		Цэцэрлэгжүүлсэн талбайн тоо		2	Албаны гадна тайлбайг тохижуулан 2 тайлбайд 65 цэцэг суулган цэцэрлэгжүүлэлт хийж 100 хувийн гүйцэтгэлтэй байна	100
3.9	Албан хаагчдын харилцаа хандлага, бусадтай зөв харилцах, хувь хүний хөгжлийн талаарх сургалт зохион байгуулах		Албан хаагчдын хамрагдсан тоо		34	Гэрэлтдэг ертөнц ТББ-тай хамтран "Ухаалаг харилцаа амжилтын эхлэл" сэдвээр бүх албан хаагчдад танхимын сургалтыг 34 албан хаагчид зохион байгуулсан.	100
3.1	Байгууллагын хаяг, нэрийн хуудас, өрөөний хаягийг хос бичгээр бичих		Хаяг байршуулсан байх		9	Хэлтсийн 8 өрөөнд 18 албан хаагчийн танилцуулгыг хос бичгээр бичин байршуулсан.	70
4	Зорилт 4. Мэдээллийн технологид суурилсан “Цахим татварын алба” болох		Цахим үйлчигээг нэвтрүүлэх	13575	14545	Цахим системийг бүрэн ашиглаж, цахимаар төлсөн татвар төлөгчийн тоог нэмэгдүүлэх	100
4.1	Татвар төлөгчийг цахимаар татвар төлөлтийг нэмэгдүүлэх		Цахимаар төлсөн татвар төлөгчийн тоо	13573	14500	Татвар төлөх үйлчилгээг ebarimt.mn, etax.mta.mn, itax.mta.mn, e-mongolia.mn, gerege.mn, smartcar.mn, ebarimt зэргийг ашиглан цахимаар авах боломжтой бөгөөд 2022 онд 15058 татвар төлөгч 7789625,2 мянган төгрөг төлсөн нь зорилтот түвшинг бүрэн хангаж 100 хувийн гүйцэтгэлтэй байна	100
4.2	e-mongolia системийн албан хаагчын хэрэглээг нэмэгдүүлэх		Хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх		34	e-mongolia, ерп системийг албаны 34 албан хаагч бүгд бүртгүүлэн ашиглаж байна.	100

Commented [OE10]: Ургалтын хувь

Commented [OE11]: Зүлэг тариагүй юм уу

Commented [OE12]: Энэ арга хэмжээ гадна тохижилт хийхэд хамааралтай юу

1	2	3	4	5	6	7	8
4.3	Сумдын татварын албан хаагчдыг тухайн сумын ЗДТГ-тай хамтран ПОС терминал төхөөрөмжөөр хангах	12 сая төгрөг	Төхөөрөмжөөр хангагдсан байх	2	10	Гурвансайхан, Дэрэн, Говь-Угтаал, Эрдэнэдалай, Баянжаргалан, Адааацаг, Дэлгэрцогт, Луус, Сайнцагаан, Дэлгэрхангай сумдад сумын ЗДТГ нь ПОС машин авч ашиглаж байна.	100
4.4	"Гэрэгэ" киоск машин байршуулах	3.5 сая төгрөг	Төхөөрөмжөөр хангагдсан байх		1	Аймгийн ЗДТГ нь 2022 оны 12 сарын санхүүжилтээр авна гэсэн тул хүлээгдэж байна.	0
Зорилтын дундаж хувь							99
Арга хэмжээний дундаж хувь 100-43 0-3 90-2 70-1 33,3-1							91.6
Үнэлгээний дундаж хувь							95.3

Төлөвлөгөөг хянасан:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн Ерөнхийлөн захирагч

..... /Ц.МӨНХБАТ/

(гарын үсэг)

(огноо)

.....

Төлөвлөгөө тайлагнасан:

ХЭЛТСИЙН ДАРГА

(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн Шууд захирагч

..... /М.ТУЯАЦЭЦЭГ/

(гарын үсэг)

2022.12.15